БАТЛАВ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА: Н.ОТГОНБАЯР

# ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2016 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2016.02.19 Улаанбаатар хот

| **Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | | **Хариуцах албан хаагчийн нэр** |
|---|---|---|---|
| | **Арга хэмжээний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшин** | **Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин** | |
| 1 | 2 | 3 | 4 |
| **1. “Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх, худалдан авах ажиллагааны талаарх төрийн бодлого,** | | | |
| 1.1.1. Худалдан авах ажиллагаанд хэрэглэгдэж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэн хүргүүлэх | 1. Хагас, бүтэн жилд Худалдан авах ажиллагааны газрын хэлтсүүдийн үйл ажиллагаа, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээний биелэлтэнд дотоод хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх, | 1. Дотоод хяналт, шалгалтын ажлыг хагас жил, жилээр хийсэн байна. | Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүд |
| | 2. Шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан, газрын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтээс санал авч, хууль санаачлагчид хүргүүлэх./жилдээ/ | 2. Шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, иргэд олон нийтээс санал авч тусган, хууль санаачлагчид хүргүүлсэн, батлуулсан байна. | |
| 1.2.2. Худалдан авах ажиллагааны газрын 2017 оны төсвийн төлөвлөлт, 2016 оны төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтыг хэрэгжүүлэн, хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах | 1.Төсвийн төлөвлөлт, хувиарлалт, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, | 1. Төсвийн төлөвлөлт, хувиарлалт, зарцуулалт үр ашигтай, сайжирсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Газрын нягтлан бодогч, няравын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, | 2. Нягтлан бодогч болон няравын үйл ажиллагаа сайжирсан байна. | |
| | 3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлж ажиллах./хагас жил, жилийн эцэст/ | 3. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж хэвшсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3.3. Албанд томилогдох, чөлөөлөгдөх албан хаагчдад төрийн болон албаны нууцтай танилцах, сахин мөрдөхөд чиглэсэн эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, нууцын баталгааг бичгээр гаргуулан авах ажлыг хэрэгжүүлэх | 1.Нууцын баталгаа гаргуулах, Эрх зүйн зөвлөмж, зөвлөгөө мэдээллээр хангах,/тухай бүрт/ | 1. Төрийн нууцын тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, албан хаагчдын ёс суртахууны ухамсар, хариуцлага дээшилнэ. | Б.Буяннэмэх |
| 2. **"Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй,** | | | |
| 2.1.4. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг хангах | 1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанаа байршуулах,/2-р сард/ | 1. Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг газрын удирдлагаар батлуулж, газрын цахим хуудсанд байршуулсан байна. | М.Ариунжаргал<br>Б.Марс-Од |
| | 2. Хийсэн хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх,/тухай бүрт/ | 2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | |
| | 3. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээллэх./улирал, хагас жил, жилийн эцсээр/ | 3. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаар газрын удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна. | |
| 2.2.5. Худалдан авах ажиллагааны чанар хүртээмж, үйлчилгээний үр дүн, тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хариуцлага тооцох системийг бүрдүүлэн, гүйцэтгэлийг зохион байгуулах | 1.Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үйлчилгээний үр дүн, тайлан мэдээнд сар, улирал, бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийх, | 1.Худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үйлчилгээний үр дүн, тайлан, мэдээнд сар, улирал, жилээр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн байна. | М.Ариунжаргал<br>Б.Марс-Од |
| | 2.Хийсэн хяналт шинжилгээний талаар зөвлөмж боловсруулах, танилцуулах, Газрын удирдлагыг мэдээллээр хангах./жилдээ/ | 2.Хийсэн хяналт шинжилгээний талаар зөвлөмж хүргүүлж, Газрын удирдлага мэдээллээр хангагдсан байна. | |
| 2.3.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх асуудлаар орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжид зөвлөгөө өгөх, гарын авлага боловсруулж, мэргэжил арга зүйн | 1. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдэд худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх асуудлаар зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, | 1. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүд хуулийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх асуудлаар нэгдсэн ойлголтонд хүрсэн байна. | Г.Баярсайхан<br>Б.Буяннэмэх<br>М.Ариунжаргал<br>Б.Марс-Од |
| | 2. Гарын авлага боловсруулж, танилцуулах./жилдээ/ | 2. Энэ талаар гарын авлага боловсруулагдаж, орон нутгийн нэгжүүдэд хүргэгдсэн байна. | |
| **4. "Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг дээшлүүлэх"** *стратеги* | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 4.1.7. Худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн мэдээллийн санд хяналт тавьж, худалдан авах ажиллагааны үйл явцад мониторинг хийх | 1. Мэдээллийн санд мониторинг хийж, газрын даргад танилцуулах, зөвлөмж боловсруулах, | 1. Мэдээллийн санд мониторинг хийж, газрын удирдлагыг мэдээллээр хангасан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шийдвэр гарсан ажлуудаас түүвэрлэн хяналт хийх./улирал, хагас жил, жилээр/ | 2. Гэрээ байгуулсан болон мэдэгдэл хүргэгдсэн ажлуудад түүвэрлэн хяналтыг хийсэн байна. | |
| 4.2.8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх | 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх./улирал тутуамд/ | 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шалгалтыг хийж, үнэлгээ гарган, газрын удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| 4.3.9. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнгийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлохоор ТСХ-ээс хийсэн судалгааны үр дүнд мониторинг | 1. Санал асуулгын дүнд дүгнэлт хийх, | 1. Санал асуулгын дүнгийн талаар дүгнэлт хийж, цаашид авах авах арга хэмжээг тодорхойлж, газрын удирдлагад танилцуулсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох./жилдээ/ | | |
| 4.4.10. Эрсдлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | 1. Худалдан авах ажиллагааны газрын эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах /1-р улиралд/ | 1. Эрсдлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан, батлуулсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Эрсдлийн үнэлгээг хийх /2-р улиралд/ | 2. Эрсдлийн үнэлгээг хагас жил, жилээр хийсэн байна. | |
| | 3. Хэрэгжилтийг хангах /Жилдээ/ | 3. Үр дүнг газрын удирдлагад танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж гаргасан байна. | |
| 4.5.11. Үнэлгээний хороо шуурхай, шударга ажиллахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 1. Үнэлгээний хороо байгуулах тушаалын төсөл боловсруулж, Газрын даргад танилцуулан батлуулах, | 1. Үнэлгээний хороог санамсаргүй сонголтын аргаар байгуулж, тушаалын төслийг албажуулсан байна. | |
| | 2. Үнэлгээний хороодын үйл ажиллагаанд хяналт тавих, | 2. Үнэлгээний хорооны үйл ажиллагаанд нь хяналт тавьж, зөвлөмж гаргасан байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | 3. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг санамсаргүй сонголтын аргаар бүрдүүлэхэд оролцох, | 3. Цахим худалдан авах ажиллагааны системд тендер шалгаруулалтын үр дүн ил тод бүрэн нийтлэгдсэн байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 4. Зөвлөмж гаргах, | | |
| | 5. Шалгарсан аж ахуй нэгжийн тендерийн материал, үр дүнг цахим худалдан авах ажиллагааны системд ил тод мэдээлсэн байдалд хяналт тавих./жилдээ/ | | |
| 4.6.12. Худалдан авах ажиллагааны газрын хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд дотоод аудит хийж, санхүү төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлагын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх | 1. Хөндлөнгийн аудитын шалгалтанд бэлтгэхээс гадна санхүүгийн тайлангийн үнэлгээ гаргах./хагас жил, жилийн эцэст/ | 1. Хөндлөнгийн аудитын шалгалтанд сайн, амжилттай дүгнүүлсэн байна. | Б.Марс-Од |
| 4.7.13 Төсвийн төлөвлөгөөний бүрдүүлэлт, тендерийн баримт бичиг борлуулсан болон бусад орлого зарлагад шалгалт хийх | 1. Хагас жил, жилээр төсвийн төлөвлөгөөний бүрдүүлэлт, тендерийн баримт бичиг борлуулсан болон бусад орлого зарлагад төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалт хийх./хагас жил, жилийн эцэст/ | 1. Төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтыг удирдамжийн дагуу хийж, хяналт шалгалтын үр дүнг газрын удирдлагад танилцуулсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| 4.8.14. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажиллагаанд хяналт тавих | 1. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах асуудлаар анхаарч, хамтран ажиллах, | 1. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдал арилсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Зөрчил дутагдлыг арилгасан болон, гарсан үр дүнг газрын цахим хуудсанд байршуулан мэдээлсэн байна./тухай бүрт/ | 2. Газрын цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байна. | |
| **5. " Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах"** *стратеги зорилтын* | | | |
| 5.1.15. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийг нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих | 1. Орон нутаг хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж боловсруулан, танилцуулах./жилдээ/ | 1. Орон нутаг хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангагдсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | | 2. Зөвлөгөө зөвлөмж хүргэгдсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.2.16. Орон нутгийн нэгжийн хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх | 1. Тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон эсэх, эрх бүхий холбогдох байгууллагад уламжлуулан шийдвэрлүүлсэн эсэхэд хяналт тавих,/жилдээ/ | 1. Тулгамдаж буй асуудал тодорхойлогдсон, эрх бүхий байгууллагад уламжлуулан шийдвэрлүүлсэн байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| 5.3.17 Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах | 1. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих,/жилдээ/ | 1. Орон нутгийн нэгжийн албан хаагчдын үйл ажиллагаа сайжирсан байна. | М.Ариунжаргал Б.Марс-Од |
| | 2. Хууль тогтоомжийг зөв хэрэглэх талаар семинар, зөвлөгөөн зохион байгуулах./жилдээ/ | 2. Хууль тогтоомжийг зөв хэрэглэх талаар семинар, зөвлөгөөн зохион байгуулсан байна. | |

Тайлбар:

1. 5-н хөтөлбөрийн хүрээнд нийт 17 арга хэмжээ төлөвлөгдсөн.
2. Энэхүү үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хяналтын сар бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээгээр тодотгон төлөвлөж, хэрэгжилтийг тооцож ажиллана.

Хянасан:

ХХХэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Буяннэмэх

Боловсруулсан:

ХХХэлтсийн мэргэжилтэн М.Ариунжаргал

ХХХэлтсийн мэргэжилтэн Б.Марс-Од